

6

МОНГОЛ ОРНЫ МАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**М.Эрдэнэчимэг**

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлүүдээс илүүтэйгээр байгаль, цаг уураас хамааралтай байдаг бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Ямар ч орны төр засгийн бодлого, үйл ажиллагааны төвд хүн амын хүнсний хангамжийн асуудал чухал байр суурь эзэлдэг билээ. Хэдийгээр хүнсний асуудал нь өнгөц харахад хувь хүний, айл өрхийн хүрээний асуудал мэт санагдавч хэрэг дээрээ улс орны үндэсний аюулгүй байдлын хэмжээний чухал асуудал байдаг. 21-р зуунд хүнсний асуудал бол дэлхий дахины хамгийн тулгамдсан асуудлуудын нэг болон тавигдаж НҮБ болон олон улсын байгууллагууд түүнийг аль болох оновчтой шийдвэрлэх талаар байнга анхааран ажиллаж байна.

Үүнтэй уялдуулан манай улс 2008 оныг “Хүнсний хангамж - аюулгүй байдлын жил” болгон зарлаж, тодорхой ажлуудыг эхлүүлж байна.

Хүнсний бодлогын асуудал нь:

1. Хүнсний хангамж, хүрэлцээ
2. Хүнсний бүтээгдхүүний эрүүл ахуй, аюулгүй байдал
3. Хүнсний бүтээгдхүүний тэжээллэг чанар гэсэн гурван үндсэн асуудлаас хамааралтай юм. Гэхдээ хүнсний бодлогын асуудал нь улс үндэстний уламжлал, зан зашил, байгаль цаг уур, газар зүйн нөхцөл зэргээс хамаарч өөр өөр чиглэлтэй байхаас гадна хамгийн ихээр буюу гол нэр төрлийн хэрэглэдэг

бүтээгдхүүнээ стратегийн бүтээгдхүүн гэж тооцдог. Манай улсын “Хүнсний хууль” – д зааснаар мах, улаан буудай нь стратегийн бүтээгдхүүн юм.

Энэ хоёр төрлийн бүтээгдхүүн нь манай орны хувьд дотоодын хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж гадаад зах зээлд экспортлох боломжтой бүтээгдхүүнүүд бөгөөд ялангуяа мах нь өөрийн орны дотоод хэрэгцээг хангаж гадаад зах зээлд нийлүүлдэг манай уламжлалт экспортын бүтээгдхүүн юм. 1990 – ээд оноос буюу зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеэс энэ үйл ажиллагаа нилээд алдагдаж, мах боловсруулах үйлдвэрүүд санхүүгийн хувьд хүндрэлд орж, хүчин чадал ашиглалт нь буурснаас үйлдвэрийн аргаар боловсруулсан махны экспортын хэмжээ эрс багассан судалгаа байдаг юм. Гэвч сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр малын тоо толгой өсөж 2007 оны байдлаар 40.0 саяд хүрсэн явдал нь мах, махан бүтээгдхүүний стратегийн ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тавигдаж байна.

Ер нь Монголчууд өдөр тутмынхаа хүнсэнд мах махан бүтээгдхүүнийг нилээд их хэмжээгээр хэрэглэдэг онцлогтой орон юм. Мах бол хүний хоногт хэрэглэх хүнсний физиологийн нормын 20 гаруй хувийг эзэлдгийн дотор өөх тосны 70.3 хувийг, уургийн 65.3 хувийг, нүүрс хүчлийн 29.5 хувийг тус тус эзэлдэг маш тэжээллэг чанар сайтай хүнс юм. Одоогийн байдлаар манай улсын жишмэл нэг хүн хоногт 240 – 270 гр мах, жилдээ 90 кг мах хэрэглэж байгаа юм. Энэ нь дэлхийд хамгийн их хэрэглээ юм. Хүн амын тоог жишмэл хүнд шилжүүлэх коэффициент 0.9 бөгөөд нэг хүний жилд хэрэглэх махны хэмжээг ашиглан нийт хүн амын хүнсэнд хэрэглэх махны хэрэгцээг тооцоход дараахь дүн гарч байна. /Хүснэгт №1/

Монгол орны хүн амын махны хэрэгцээний байдал
/бүсүүдээр/ Хүснэгт №1

Д/д	Эдийн засгийн бүсүүд /аймаг, нийслэлээр/	2006 оны байдлаар	
		Хүн ам /мян. хүн/	Хэрэгцээт мах /мян.тн/
1.	Баруун бүс:	410.0	33.2
	Баян өлгий	100.1	8.1
	Говь – Алтай	60.3	4.8
	Завхан	80.6	6.5
	Увс	80.5	6.5
	Ховд	88.5	7.1
2.	Хангайн бүс:	553.8	44.8
	Архангай	93.3	7.5
	Баян хонгор	83.8	6.7
	Булган	60.3	4.8
	Орхон	79.4	6.4
	Өвөр хангай	114.9	9.3
3.	Төвийн бүс:	436.5	35.3
	Говь сүмбэр	12.3	1.0

	Дархан – Уул	87.5	7.0
	Дорно говь	54.5	4.4
	Дунд говь	49.2	3.9
	Өмнө говь	46.5	3.7
	Сэлэнгэ	100.1	8.1
	Төв	86.4	6.9
4.	Зүүн бүс:	200.2	16.2
	Дорнод	73.6	5.9
	Сүх баатар	55.6	4.5
	Хэнтий	71.0	5.7
5.	Улаан баатар:	994.3	80.5
	Бүгд:	2594.8	210.0

Үүнээс үзэхэд 2006 оны байдлаар 2594.5 мянган хүн амд 210.0 мянган тонн мах хэрэглэх хэрэгцээ байгааг харуулж байна. Судалгаанаас үзвэл Улаан баатарын бүс нутагт манай нийт хүн амын 40-өөд хувь нь суурьшсан бөгөөд хамгийн том зах зээл нь юм.

Монгол улсын мах үйлдвэрлэлтийн байдал
/биет хэмжээгээр/

Хүснэгт №2

Д/д	Махны төрөл	2005 он	2006 он	Дүнд эзлэх хувь	
				2005	2006
	Мах /мян.тн/	386.5	354.9	100	100
1.	Тэмээний	14.0	12.1	3.6	3.4
2.	Адууны	77.0	64.3	19.9	18.1
3.	Үхрийн	91.3	85.2	26.6	24.0
4.	Хонины	118.1	116.9	30.6	32.9
5.	Ямааны	85.8	76.2	22.2	21.5
6.	Бусад	0.3	0.3	0.1	0.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Мал аж ахуйн салбарт 2006 онд 355.0 мянган тонн мах үйлдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 31.6 мянган тонноор буурсан байна. Нийт мах үйлдвэрлэлд хонины мах, үхрийн махны эзлэх хувь хэмжээ нилээд өндөр байгаа нь энэ төрлийн махны үйлвэрлэлийг түлхүү хөгжүүлэх боломжтойг харуулж байна. Үүнээс гадна нийт 355.0 мянган тонн махны үйлдвэрлэлээс Хүснэгт №1 - т тооцоолсон монгол улсын нийт хүн амын 2006 оны хэрэгцээт мах болох 210.0 мянган тонн махыг хасахад зах зээлд буюу таварт борлуулах махны нөөц нь 145.0 мянган тонн юм.

Монгол улсын махны экспортын байдал

Хүснэгт №3.

д/д	Нэр төрөл	2005 он		Нэгжийн үнэ /ам.\$/	2006 он		Нэгжийн үнэ /ам.\$/
		Тоо хэмжээ /тн/	Үнийн дүн /мян. ам. \$/		Тоо хэмжээ /тн/	үнийн дүн /мян. ам. \$/	
1.	Үхрийн шинэ мах	27.3	24.5	0.9	194.6	309.1	1.6
2.	Үхрийн хөлдүү мах	2792.4	3185.4	1.1	2659.8	4374.0	1.6
3.	Хонь, ямааны мах	32.2	66.2	2.0	270.0	0.5	0.0
4.	Адууны мах	4960.2	4759.9	1.0	8814.3	10279.4	1.2
5.	Малын дайвар бүтээгдхүүн	404.4	82.3	0.2	963.1	1133.6	1.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

Мах махан бүтээгдхүүний хувьд дотоод болон гадаад зах зээлд тавигдах үндсэн шаардлага бол махыг үйлдвэрийн аргаар боловсруулан хэрэглэгчдийн хэрэгцээнд нийлүүлэх явдал байдаг. Сүүлийн арав гаруй жил экспортод гарсан нийт махны хэмжээ буурсан хэдий ч махны экспортод үхрийн мах, адууны махны эзлэх хувь өндөр байгаа нь нэг талаас энэ төрлийн махны гадаад зах зээл дэх эрэлт их, нөгөө талаас манай улсын энэ төрлийн махны дотоод зах зээлийн эрэлтээс давсан нийлүүлэлтийн чадавхи байгааг илэрхийлж буй үзүүлэлт юм. Гэхдээ гадаад зах зээлд гаргах бүтээгдхүүний нөөцийн хэмжээгээр зах зээлийн тодорхой хэсгийг найдвартай эзэлнэ гэдэг нь харьцангуй ойлголт юм. 2006 оны байдлаар 145.0 мянган тонн махыг зах зээлд буюу таварт борлуулах боломжтойгоос ойролцоогоор 13.0 мянган тонн махыг гадаад зах зээлд борлуулсан байна. Одоогоор ажиллаж байгаа мах боловсруулах томоохон үйлдвэрүүд нь бүрэн хүчин чадлаа ашиглаж чадвал тус орны жилийн нийт мах үйлдвэрлэлийн 45-50 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулах боломжтой юм. Судалгаанаас үзвэл манай улсын үхрийн мах, адууны махны экспортлогч гол түнш нь ОХУ бөгөөд үхрийн махны экспортын 98-99 хувийг эзэлж байна. Мах, махан бүтээгдхүүний экспортыг нэмэгдүүлэхэд дараахь асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай юм. Үүнд:

1. Манай оронд мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үндсэн эх үүсвэр нь малыг махны чиглэлээр төрөлжүүлэн өсгөх, сүргийн зохистой бүтцийг бий болгож, мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах явдал юм.
2. Малын үүлдэр угсааг сайжруулах, үржлийн зөв бодлогыг хэрэгжүүлэх нь мах, махан бүтээгдхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд асар их ач холбогдолтой.
3. Мах боловсруулах үйлдвэрүүдэд бэлтгэсэн мах нь экспортын бүтээгдхүүнд тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангахаас гадна аль ч

орны баримталдаг олон улсын ХАССП-ийн шаардлагыг хангасан байх нь маш чухал юм.

4. Мөн мал эмнэлэг, хорио цээрийн үйл ажиллагааг стандартын түвшинд явуулж, МАА-н салбарт тавих хяналтыг сайжруулж, төрөл бүрийн малын халдварт өвчин түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа тогтворжуулах.

5. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуй зонхилдог манай орны хувьд эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх чиглэлээр дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6. Мах, махан бүтээгдхүүний дотоод, гадаад зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг нарийн судалж, махны экспортын стратегийн бодлогыг боловсруулах зэрэг асуудлууд юм.

Ашигласан ном зүй

1. Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал. УБ.1996
2. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ.1992
3. Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжил хөтөлбөр УБ.1999
4. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УБ.2001
5. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль УБ.2003
6. Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэлх) УБ.2003
7. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2004-2008)
8. Монгол улсын баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр (2006-2015) УБ.2005
9. Монгол улсын статистикийн эмхтгэл УБ.2005,2006